



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/1115

Чойр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5, 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоол “Шинэ сэргэлтийн бодлого” дөрөв. Хот хөдөөгийн сэргэлт, Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлагдсан “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөр, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 04 дугаар тогтоол “Нээлттэй Говьсүмбэр хөтөлбөр батлах тухай”, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 3.7.8, 3.7.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн 3 байршилд “нийтийн орон сууцны төсөл сонгон шалгаруулах”, “50 хаус хороололын төсөл сонгон шалгаруулах” ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Наранбаатар

(Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Т.Бат-эрдэнэ

(Сүмбэр сумын Засаг дарга)

Г.Хонгор

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Б.Хорол

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Баяржаргал

(Аймгийн ерөнхий архитектор)

Б.Даваажаргал

(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Х.Алтанцэцэг

(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Л.Мөнгөнцэцэг

(Говьсүмбэр аймгийн барилгачдын холбооны тэргүүн)

Д.Баясгалан

(Ус-Ду ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

Б.Элдэв-Очир


4212400271

Нарийн бичгийн дарга: (БЗӨБЦТС ТӨХК Говьсүмбэр салбар сүлжээний ерөнхий инженер)
Н.Мөнхсүвд
(Хөндлөнгийн төлөөлөл)
А.Алтаншагай
(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Төсөл сонгон шалгаруулах орон нутгийн өмчид бүртгэлтэй газрын ашиглалтад эзэмшигчийн зүгээс хяналт тавих ажлыг Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосугай.

3.Дээрх ажлыг холбогдох хууль, тогтоомж, ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ